

АЛБАН ШААРДЛАГЫН БИЕЛЭЛТ

№	Албан шаардлага	Албан шаардлагын биелэлт
1	"ОХУ-аас БНХАУ-руу Монгол Улсын нутгаар даран өнгөрөх хий дамжуулах хоолойн трассын нутаг дэвсгэрийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх төсөл"-өөс тухайн ажилд хамааралгүй өрөөний засварын зардалд 22,000,000.00 төгрөгийг зарцуулж, 31,428,160.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэн, Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авч, орлогоор бүртгэсэн.	2022 оны 3 дугаар улиралын байдлаар тухайн байгууллагад хэрэгжиж буй төсөл хөтөлбөр болон нэмэлт ажлын санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулаагүй бөгөөд тухайн санхүүжилтаар орж ирсэн мөнгийг өрөөний засвар болон үндсэн хөрөнгө болон бараа материал бэлтгэхтэй холбоотой зардалд зарцуулаагүй болно.
2	Төсвийн хөрөнгөөр үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардалд буюу үндсэн хөрөнгө бэлтгэхэд 12,116,300.00 төгрөг, газрын харилцааны тэргүүний ажилтны тэмдэг хэвлүүлэхэд 10,370,000.00 төгрөг, нийт 22,486,300.00 төгрөгийг зарцуулсан.	2022 оны 3 дугаар улиралын байдлаар тухайн байгууллага нь төсвийн хөрөнгөөр үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардалд буюу үндсэн хөрөнгө бэлтгэхэд мөнгө зарцуулаагүй. Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөгө болон ажиллаж байна.
3	Газрын кадастрын зураглал хэвлэх үнэт цаасны тендерт Монголын үнэт цаас хэвлэл ХХК шалгарч нэгжийн үнийг 220.00 төгрөгөөр тогтоон гэрээ байгуулсан боловч нэмэлт гэрээ байгуулан 485.00 төгрөгөөр бүтээгдэхүүн нийлүүлэн 5,307,900.00 төгрөгийг илүү төлсөн.	2022 оны 3 дугаар улиралын байдлаар тухайн байгууллагад нийлүүлсэн бараа материалын нэгжийн үнийн дүн болон тоо ширхэг нь тухайн аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний үнийн дүнтэй зөрүүгүй байгаа бөгөөд тухай бүр нь хяналт тавин ажиллаж байна.
4	Ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд ур чадварын нэмэгдэл олгохоор гэрээний заалтанд тусгасан	Ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд ур чадварын нэмэгдэл олгохгүй байгаа бөгөөд тухайн ажилтантай байгуулсан гэрээний заалтанд тусгахгүй байгаа болно.